

БНХАУ-аас Тайваньд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа

Жамбалдоржийн Баярбаатар^{ID}

Аюулгүй байдал судлалын хүрээлэн,

Улаанбаатар хот, Монгол Улс

bayarbaatar.j@niss.gov.mn

Хураангуй: БНХАУ-аас Тайваньд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа нь “Тайванийг өөртөө нэгтгэх” зорилтын дор 1949 оноос хойш тасралтгүй үргэлжилж байна. Хятадаас Тайваньд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа нь түүний эрх баригчдын дэвшиулсэн “Нэг Хятад” бодлогод суурилж, аажмаар энэ нь “Нэг Хятад, Хоёр Систем”-ийн бодлого буюу “хатуу”-гаас “зөөлөн” арга хэлбэрт шилжих замаар дүр төрхөө өөрчилжээ. Энэ нь “Хүйтэн дайн”-ы дараах геополитикийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт, Тайванийг хамгаалах АНУ-ын амлалт зэрэгтэй уялдсан бодлогын томоохон шилжилт юм. Гэвч сүүлийн жилүүдэд Тайванийн Ардчилсан дэвшилт намын эрх баригчид “Тайвань аль хэдийн тусгаар тогтносон улс”, “Эх газар, Тайвань хоёр нь харилцан хамааралгүй” зэрэг байр суурь илэрхийлэх болсон нь Хятадын эрх баригчдыг түгшээн, “шаардлагатай тохиолдолд цэргийн хүч хэрэглэхээ буцахгүй” хэмээн мэдэгдэж, Тайвань арлыг тойрсон томоохон цэргийн сургуулилт явуулах болсон нь бүс нутгийн нөхцөл байдлыг хурцатгаж байна. Иймд бид энэхүү судалгаагаар, “Хоёр эрэг”-ийн харилцааны түүх, одоохи нөхцөл байдал, Эх газраас Тайваньд хэрэгжүүлж буй бодлогын өөрчлөлт, ялангуяа түүний “Тайванийг энх тайвнаар нэгтгэх” үйл ажиллагааны онолын үндэслэл, хэрэгжүүлж буй арга хэлбэр, Тайванийн хариу үйлдэл, тэдгээрт нөлөөлөх дотоод, гадаад хүчин зүйлийг авч үзэв.

Түлхүүр үгс: “Хоёр эрэг”, “Эх газар”, Тайвань, “Нэг Хятад, Хоёр систем”, “92 оны зөвшилцөл”, “Дайны 3 номлол”



Нэг. “Хоёр эрэг”^{*} -ийн харилцаа: Түүхэн эхлэл, одоох байдал, бодлого, үйл ажиллагаа

БНХАУ-ын дотоод дахь иргэний дайнд ялагдал хүлээсэн Чан Кайши тэргүүтэй Гуоминь дан-ы эрх баригчид 1949 онд Тайваньд зугтан гарсанаас хойш Эх газраас Тайванийг өөртөө нэгтгэн авах хүчин чармайлт өнөөдрийг хүртэл 75 жилийн турш тасралтгүй үргэлжилж байна. Тайванийг өртөө нэгтгэх санаархал нь нэг талаас Хятадын дотоод асуудал мэт ойлгогдож буй ч Тайванийн газар зүйн өвөрмөц байршил нь геополитикийн онолын үүднээс Хятадын бүс нутаг, олон улс дахь цэрэг стратегийн байр суурийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтойг харж болно.

Их Британийн эрдэмтэн Халфорд Жон Макиндерийн “Зүрхэн газар” (“Heart Land”)

онолоор “Евроазийн эх газарт ноёрхсон улс . . . дэлхийд ноёрхоно”.¹ Харин уг онолыг сөргүүлэн дэвшүүлсэн “Далайн хүч” (“Sea Power”) онолын үндсэн томъёолол нь “Дэлхийн далайг эрхшээгч нь дэлхийг эрхшээх” бол уг онолын хүрээнд гарч ирсэн “Зах хөвөө тэнгис” (“Marginal Seas”)-ийн стратегид “Зах хөвөө тэнгист хяналтаа тогтоосон нь дэлхийг хянаж чадах” ажээ.²

2013 оноос хойш олон улс, бүс нутагт хэрэгжүүлж буй Хятадын гол стратеги нь “Бүс ба Зам” төсөл юм. Уг төслийн хүрээнд тодорхойлсон далайн зам нь чухамхүү зах хөвөө тэнгисийн шугамтай давхцаж буйг дараах зураг (Зураг 1)-т т тодорхой харуулав:

Зураг 1. БНХАУ-ын “Бүс ба Зам” төсөл.



Эх сурвалж: Хятадын “Бүс ба Зам” төсөл,

[The belt and road initiative routes | Download Scientific Diagram](#)

^{*} “Хоёр эрэг”, “Эх газар”, “92 зөвшилцөл” гэдэг нь хятад судлаачдын хувьд тогтсон ойлголт, хэллэг: “Хоёр эрэг” гэдэг нь нэг талаас, БНХАУ-ыг нөгөө талаас Тайванийг заасан буюу “Хоёр эрэг”-ийн харилцаа гэвэл БНХАУ-Тайванийн харилцааг хэлдэг. “Эх газар” гэдэг нь БНХАУ-ыг заана. “92 зөвшилцөл” гэдэг нь хятад, тайванийн талаас 1992 оны 10-12-р сард Хонкогт хийсэн уулзалтаар цаашид талууд “Нэг Хятад” (“Нэг улс, Хоёр систем”) зарчмын дор асуудлаа шийдвэрлэхээр зөвшилцсөнийг ойлгодог. Гэвч талууд “Нэг Хятад” зарчмыг өөр өөрөөр тайлбарладаг буюу одоог хүртэл нэгдсэн “зөвшилцөл”-д хүрээгүй.


¹ Hayley Stainton. “Mackinder’s Heartland Theory made SIMPLE” [“Макиндерийн ‘Зүрхэн газар’ онолын хураангуй”]. The Geography Teacher, 2024 оны 10-р сар. [Mackinder's Heartland Theory made SIMPLE - The geography teacher](#)

² Фүжий Генкий, Хамгийн хүчирхэг зэвсэг бол геополитик, (Fujii Gemki Printed in Japan, 2016), (монгол хэвлэл, Орч., Ц.Буянцогтоо, УБ, 2025), 26.

Хятадын эх газрын үргэлжлэл нь Өмнөд Хятадын тэнгис, Дорнод Хятадын тэнгисээр хязгаарлагдах бөгөөд Тайванийн байршил энэ хоёр тэнгисийн голд оршино. Иймд Тайванийг өөрийн мэдэлд авах нь Өмнөд Хятадын болон Дорнод Хятадын тэнгист хяналтаа тогтоох давуу

талыг хятадын талд олгоно. Эдгээр тэнгис нь АНУ-ын улс төрч Жон Ф.Даллесийн тодорхойлсноор “Нэгдүгээр цуваа арлууд”-ын шугамд хамаарах буюу тус бүс нутгийн цэрэг стратегийн хамгийн чухал байрлалд тооцогдоно.³ Үүнийг дараах зураг (Зураг 2)-г харуулав:

Зураг 2. БНХАУ-ын “Бүс ба Зам” төсөл.



Эх сурвалж: 1st-and-2nd-island-chains,

[1st-and-2nd-island-chains | Center for International Maritime Security](#)

Зөвхөн цэрэг, стратегийн төдийгүй 2.45 их наяд ам.долларын бараа бүтээгдэхүүн буюу дэлхийн далай тээврийн 20 хувь дамжин өнгөрдөг Тайваний хоолой, буюу 700 сая хүн ам оршин суудаг Зүүн Өмнөд Азийн улс орнуудыг Ази, Европ, Африк, Америктай холбодог логиستيкийн гол зангилаа, сүүлийн үеийн хамгийн дэвшилтэт хагас дамжуулагчийн 90 хувийг үйлдвэрлэдэг⁴ Тайваньд хяналтаа тогтоох нь Хятадын улсын худалдаа, эдийн засаг, өндөр технологийн

салбарын хөгжилтэй уялдсан томоохон стратеги юм.

Иймд Эх газраас “Нэг Хятад” зарчмыг дэвшүүлж, Тайванийг өөртөө нэгтгэх бодлого, үйл ажиллагааг уг зарчмын дор хэрэгжүүлж ирсэн нь одоог хүртэл “Хоёр эрэг”-ийн харилцаан дахь хятадын талын байр суурийг тодорхойлж байна. Тайванийг өөртөө нэгтгэх Хятадын стратеги нь “Нэг Хятад” зарчимд суурилж, дараах байдлаар хувирч өөрчлөгдөж ирэв:

³ Enoch Wong. “What is the US’ island chain strategy and what does it mean for China?” [“АНУ-ын цуваа арлуудын стратеги ба энэ нь Хятадын хувьд юуг илэрхийлэх вэ?”], Jun 16, 2025. [Explainer | What is the US’ island chain strategy and what does it mean for China? | South China Morning Post](#)

⁴ Thibault Denamiel and Evan Brown, “The State of Maritime Supply-Chain Threats” [“Далайн ханган нийлүүлэлтийн сүлжээний аюул заналын байдал”], November 4, 2024. [The State of Maritime Supply-Chain Threats](#)

Хатуу байр суурь буюу цэрэг, зэвсгийн хүчийг ашиглах

БНХАУ-ын эрх баригчид эхэн үедээ Тайванийг өөртөө нэгтгэхэд хатуу бодлого баримталж, цэрэг зэвсгийн хүч хэрэглэхээс үл буцаж байв. Харин тайванийн талаас “Нэг Хятад” зарчмыг үг, үйлдлээрээ хүлээн авахаас татгалзсан хэвээр бөгөөд энэ нь “Хоёр эрэг”-ийн харилцааг гурвантаа аюултай нөхцөл байдалд оруулсан.

Эхний удаад буюу 1954-1955 онд Хятадын ардын чөлөөлөх арми тайваньчуудын хориглолтын бүс И Зяншань арал (одоогийн БНХАУ-ын Жэцзян мужийн нутаг дэвсгэр)-ыг довтолон эзэлсэн бол хоёр дахь удаа 1958 онд

Тайванийн Зиньмэнь болон Мазу арал руу хүнд артиллер, агаарын довтолгоог хослуулан хийжээ. Хятадын хоёр дахь довтолгоо АНУ-аас Тайваньд үзүүлсэн улс төр, цэрэг зэвсгийн дэмжлэгийн нөлөөгөөр амжилтад хүрч чадалгүй зогссон.⁵ Энэхүү довтолгооны дараа Хятадын Батлан хамгаалахын сайд Пөн Дөхуай “Тайвань ахан дүүст хүргэх мэдэгдэл” гаргасны дотор “Тайвань . . . бол Хятадын нэг хэсэг бөгөөд өөр нэгэн улс биш юм. Дэлхий дээр зөвхөн нэг Хятад бий, хоёр Хятад гэж байхгүй” хэмээн хатуу байр суурь илэрхийлжээ.⁶

Энх тайвнаар нэгтгэх буюу “Нэг улс, Хоёр систем”-ийн бодлого

1954, 1958 онуудад Тайваньд цэргийн хүчээр халдан довтолсны дараа Хятадын эрх баригчид олон улс дахь нөлөө, байр сууриа бэхжүүлэх чиглэлээр идэвхтэй ажилласан нь зохих үр дүнгээ өгчээ. НҮБ-аас 1971 оны 10-р сарын 25-ны өдөр Тайванийн гишүүнчлэлийг Ерөнхий Ассемблейн 2758 дугаарт тогтоолоор хүчингүй болгож, түүний орыг БНХАУ-д шилжүүлсэн нь олон улс дахь Хятадын байр суурийг өсгөв.⁷

БНХАУ-д өрнөсөн “Соёлын хувьсгал”-ын дараа буюу 1978 онд ХКН-ын шинэ удирдлага “Өөрчлөлт, нээлттэй хаалганы бодлого”-ыг дэвшүүлж, эдийн засгийн хөгжлийг улс орны бүтээн байгуулалтын стратегийн чухал зорилт болгосон нь Тайванийг цэрэг, зэвсгийн хүчээр эзлэн авах үзэл санаанд нь тусгалаа олжээ.

Тухайлбал, БНХАУ-ын Ардын төлөөлөгчдийн их хурлын Байнгын хороон дарга Е Зень-ин “Тайвань ахан дүүст хүргэх мэдэгдэл”-дээ “Тайванийг чөлөөлөх” гэх утгыг “Энх тайвнаар нэгтгэх” хэмээн өөрчилсөн нь хятадын талын бодлогод томоохон өөрчлөлт авчрав.⁸ 1979 оны 1-р сарын 1-нд БНХАУ-ын Засгийн газар АНУ-тай дипломат харилцаа тогтоосны дараа хятадын тал “. . . Зиньмэнь арлууд зэрэг Тайванийн газар нутагт нуужингийн цохилт өгөхөө зогсоож буй”-гаа мэдэгджээ. “Хоёр эрэг” албан ёсоор энх тайвны гэрээнд гарын үсэг зураагүй ч дээрх мэдэгдлийн дагуу гал зогсоох харилцан зөвшилцөл өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна.⁹

Тайванийг “энх тайвнаар нэгтгэх” бодлогын гол агуулга нь “Нэг улс, Хоёр систем” зарчим юм.

⁵ 呂昭隆, “40 年前今天 兩岸靠默契停火[金門炮擊 沒有白紙黑字簽署文件 說停就停]” [“40 жилийн өмнө ‘Хоёр эрэг’ чимээгүй гал зогсоов”], 2019 оны 1-р сарын 1. [40 年前今天 兩岸靠默契停火 - 兩岸要聞 - 中國時報 \(chinatimes.com\)](http://40年前今天 兩岸靠默契停火 - 兩岸要聞 - 中國時報 (chinatimes.com))

⁶ 朱誠亮, 「中共對台政策演變論析」 [“Хятадын коммунист намаас Тайваньд хэрэгжүүлсэн бодлогын өөрчлөлтөнд хийсэн дүн шинжилгээ”], 吉林省教育學院學報, 總 231 期, 2010 年第 3 期, 頁 134.

⁷ 大会决议, 二七五八(二十六) . 恢复中华人民共和国在联合国的合法权利 [“Ерөнхий ассемблейн шийдвэр, 2758: БНХАУ-ын НҮБ дахь хууль ёсны эрх ашгийг сэргээв”], 1971 оны 10-р сарын 25. [联合国大会第 26 届会议 | 大会决议 A/RES/2758\(XXVI\) \(un.org\)](http://联合国大会第 26 届会议 | 大会决议 A/RES/2758(XXVI) (un.org))

⁸ 劉遺倫, 「中國對台政策的歷史演變」 [“Хятадаас Тайваньд хэрэгжүүлсэн бодлогын түүхэн өөрчлөлт”], 黨史文苑, 2005 年第 6 期, 頁 15.

⁹ 呂昭隆, “40 年前今天 兩岸靠默契停火[金門炮擊 沒有白紙黑字簽署文件 說停就停]” [“40 жилийн өмнө ‘Хоёр эрэг’ чимээгүй гал зогсоов”], 2019 оны 1-р сарын 1. [40 年前今天 兩岸靠默契停火 - 兩岸要聞 - 中國時報 \(chinatimes.com\)](http://40年前今天 兩岸靠默契停火 - 兩岸要聞 - 中國時報 (chinatimes.com))

1982 оны 9-р сард Дэн Сяопин Английн Ерөнхий сайд Маргарет Тэтчертэй уулзах үедээ, “Нэг улс, Хоёр систем”-ийн агуулгыг яриандаа тусгаж, “энэ нь Хонконгийг Эх газарт буцаан авах асуудлыг шийдвэрлэх хамгийн зөв шийдэл” хэмээн үзэж буйгаа илэрхийлэв. Түүний улс төрийн үзэл санаа нь “ХКН нь цорын ганц эрх баригч хүчин бөгөөд улсын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Харин Тайвань, Хонконг, Макао нь засаг захиргааны тусгай бүс болох бөгөөд тухайн бүс нутгийн хэмжээндээ улс

төр, хууль, цэргийн захиргаа зэргийг хариуцан захирч болно”¹⁰ гэх агуулгатай. 1982 онд шинээр батлагдсан “БНХАУ-ын Үндсэн хууль”-д “Засаг захиргааны онцгой бүс” гэх томъёоллыг оруулснаар “Нэг улс, Хоёр систем” нь хуулийн үндэслэлийг олж авчээ.¹¹ 1984 он 9-р сарын 15-ны өдөр Дэн Сяопин-ы “Нэг улс, Хоёр систем” өгүүлэл хэвлэгдэж, “Нэг улс, хоёр системийн бодлого нь ХКН-аас “Эх орноо нэгтгэх” асуудлыг шийдвэрлэх гол чиглэл” болохыг бататгав.¹²

Цэрэг, зэвсгийн хүчээр “Тайванийг өөртөө нэгтгэх”-ээс үл татгалзана

Тайванийн Ерөнхийлөгч Ли Дэньхуй-н 1995 онд АНУ-д хийсэн айлчлал, 1996 оны Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор хятадын тал 2 удаа байлдааны пуужин харвах өргөн далайцтай цэргийн сургуулилт хийсэн нь Тайванийн хоолойд дайн дэгдээж болзошгүй 3 дахь аюулыг бий болгов.¹³ Түүнчлэн 2022 оны 8-р сарын 2-ны өдөр АНУ-ын Төлөөлөгчдийн тэнхимийн тэргүүн, хатагтай Нэнси Пелоси Тайваньд айлчлах үеэр хятадын тал хүчтэй эсэргүүцэл илэрхийлж, Хятадын ардын чөлөөлөх арми Тайвань арлыг бүсэлсэн цэргийн томоохон сургуулилтыг зохион байгуулав. Хэдийгээр энэхүү цэргийн сургуулилтын цар хүрээ нь хязгаарлагдмал ч Тайвань хоолойд дайн дэгдээж болзошгүй дөрөв дэх аюулд ойрхон байсныг судлаачид онцолж байв.¹⁴

Тайванийг цэрэг, зэвсгийн хүчээр эзлэн авах нь Хятадын эрх баригчдын бодлогын суурь номлол хэдий ч 1979 оноос хойш түүнд томоохон

өөрчлөлт орсныг дээр дурдсан. БНХАУ-ын шинэ стратегитай уялдан Тайванийг энх тайвнаар өөртөө нэгтгэх нь ХКН-ын цэрэг, зэвсгийн хүч буюу хатуу байр суурийг “зөөллөж” өгсөн. Гэвч ХКН-аас Тайваньд цэргийн хүч хэрэглэх бодлогоо одоог хүртэл хадгалсан хэвээр байна. Тухайлбал, 1984 онд ХКН-ын Төв хорооны зөвлөгөөн дээр Дэн Сяопин, “Хятад улс Хонконг болон Тайвань гэсэн хоёр асуудалтай нүүр тулаад байна. Асуудлыг шийдвэрлэх хоёрхон арга зам бий. Нэгдүгээрт, яриа хэлэлцээр, хоёрдугаарт, зэвсгийн хүч хэрэглэх. Бид Тайванийн асуудлыг энх тайвнаар шийдвэрлэхийг хэзээд эрмэлзэнэ. Гэвч энх тайвны бус арга замаар Тайванийг нэгтгэх магадлалыг үгүйсгэхгүй”¹⁵ гэв.

2022 онд БНХАУ-ын дарга Ши Жиньпин ХКН-ын 20 дугаар бүгд хурал дээр тавьсан илтгэлдээ, “Тайвань бол Хятадын Тайвань. Тайванийн асуудлыг шийдвэрлэх нь хятад иргэдийн үйл хэрэг бөгөөд зөвхөн тэд л шийдвэрлэнэ. Бид хамгийн

¹⁰ 周建勝, 「一國兩制是國家統一模式的政治倫理創新」 [“Нэг Хятад, Хоёр улс тогтолцооны улсыг нэгтгэх хэлбэрийн улс төрийн онолын санаачлага”], 成都大學學報(社科版) 2010 年第 4 期, 頁 10.

¹¹ БНХАУ-ын Үндсэн хууль, 3-р бүлэг, 62-р зүйл, 62.14 дэх хэсэг, 1982 он. “Замбуулин” сэтгүүл, 2019, №1, 135.

¹² 空軍備役中校, 唐仁俊, [當前中共對台統戰策略之分析] [“Хятадын коммунист намаас Тайваньд хэрэгжүүлж буй нэгтгэх бодлогод хийсэн дүн шинжилгээ”], 空軍軍官雙月刊第 158 期, 頁 32.

¹³ BBC News, “台灣海峽歷次危機回顧：從一江山島戰役、金門炮戰到飛彈危機 看中美台三角關係演繹” [“Тайвань хоолойн түүхэн аюулыг эргэн сөхөхүй: И Зеньшань, Зиньмэнь арлын тулаан, пуужингийн аюул занал хүртэл Америк, Хятад, Тайванийн гурвалсан харилцааг тайлбарлах нь”], 2022 оны 8-р сарын 26. [台灣海峽歷次危機回顧：從一江山島戰役、金門炮戰到飛彈危機 看中美台三角關係演繹 - BBC News 中文](#)

¹⁴ Rupert Wingfield-Hayes, “As it happened: China plans show of force after Pelosi's visit to Taiwan” [“Хэрэг явдал ингэж өрнөв: Пелосын Тайвань дахь айлчлалын дараа Хятад цэргийн хүч үзүүлэхээр төлөвлөв”], August 3, 2022. [As it happened: Pelosi in Taiwan - China plans show of force after Pelosi's visit - BBC News](#)

¹⁵ 鄧小平, 鄧小平文選第 3 卷 [“Дэн Сяопин-ий сонгомол, 3-р боть”], (台北: 地球出版社, 1994 年), 頁 94.

чигч шударга хүчин чармайлтаар энх тайвнаар нэгтгэхийг зорино. Гэвч цэрэг, зэвсгийн хүчийг үл ашиглана хэмээн амлахгүй. Аливаа шаардлагатай арга хэмжээг сонгон авч хэрэгжүүлэх нь гадаадын хүчний оролцоо болон “Тайванийн тусгаар тогтнол”-ыг эрэлхийлэгч цөөн хүчин, тэдгээрийн

Дотоод хүчин зүйлийн хувьд, Тайванийн эдийн засгийн хүчин чадал, улс төр, нийгмийн тогтолцоо, иргэний нийгэм дэх ардчилсан үзэл санаа бөгөөд түүнийг түүчээлэгч Ардчилсан дэвшилт нам зэрэг улс төрийн хүчин болно.

Гадаад хүчин зүйлийн хувьд, “Хоёр эрэг”-ийн харилцаан дахь АНУ-ын эрх ашиг, оролцоо юм. Америк, Тайванийн харилцааг 1979 оны 1-р сарын

Дээрх бүгдийг нэгтгэн дүгнэвэл

- Эх газраас Тайваньд чиглэсэн бодлого нь “Нэг Хятад” зарчимд суурилж ирсэн. Тайванийг өөртөө нэгтгэх бодлого, үйл ажиллагааг уг зарчмын дор хэрэгжүүлж буй нь одоог хүртэл “Хоёр эрэг”-ийн харилцаан дахь хятадын талын байр суурийг тодорхойлж байна;

- “Хоёр эрэг”-ийн хурцадмал байдлыг өдөөсөн дээр дурдсан гурван тохиолдол нь хятадын талаас Тайваньд тулгасан “Нэг Хятад” зарчмын хатуухан илрэл ч бодит байдал дээр Эх газраас “Тайванийг өөртөө нэгтгэх” зорилтыг

үйл ажиллагааны эсрэг чиглэнэ. . . ”¹⁶ хэмээн Дэн Сяопин-ий байр суурийг бататгажээ. Хятадын тал хэдийгээр цэрэг, зэвсгийн хүчээр Тайванийг өөртөө нэгтгэхээс үл буцахаа байнга илэрхийлдэг ч үүнд “саад” болж буй дотоод, гадаад хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд: 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн “Тайваньтай харилцах акт”-аар¹⁷ тодорхойлсон. Уг актын дагуу америкийн тал Тайваньд шаардлагатай батлан хамгаалах дэмжлэг үзүүлэх зохицуулалт өнөөг хүртэл Эх газраас Тайваньд хэрэгжүүлж болзошгүй цэргийн бодит заналхийллээс хамгаалах чухал хүчин зүйл болж байна.

бүрэн хэрэгжүүлэхэд хангалтгүй нь батлагдаж байна. Иймд “Нэг Хятад” зарчим нь “Нэг улс, Хоёр систем”, “92 зөвшилцөл” зэргээр дүрээ хувиргах, уг зарчмыг хэрэгжүүлэх аргын хувьд хувьд “зөөлөн хүч”-д зайгаа тавьж өгөх хэлбэрт шилжиж байна;

- Гэхдээ ямар ч тохиолдолд хятадын талын үндсэн байр суурь хэвээр бөгөөд зөөлөн хүч үр дүнд хүрэхгүй бол хатуу буюу зэвсгийн хүчээр Тайванийг эзлэх бодлогоо гадаад, дотоодод ил тодоор мэдэгдэж буйгаас тодорхой харагдаж байна.

Хоёр. Хятадаас Тайваньд хэрэгжүүлж буй зөөлөн хүчний бодлого, үйл ажиллагааны онолын үндэс: “Дайны 3 номлол”

Хятадын ардын чөлөөлөх армийн орчин цагийн цэргийн номлол, стратеги, тактикт Персийн булангийн дайн томоохон нөлөө үзүүлсэн.¹⁸ АНУ-аас 1991 онд хэрэгжүүлсэн “Цөлийн шуурга” ажиллагааны дараахан нийтлэгдсэн Хятадын Цэргийн шинжлэх ухааны академи, Стратегийн академийн захирал асан, хошууч генерал Ван Пуфөн-ий өгүүлэлд энэ

талаар анх дурджээ. Тэрээр “Мэдээллийн дайны сорилтууд” өгүүлэлдээ, “Мэдээллийн дайнд хэрхэн давуу тал олж авах вэ? . . . Зөвхөн буу зэвсэг бүхий байлдааны талбарт бус компьютержсон тухайлбал, лаборатори, хяналтын өрөөнд. Тэнд

¹⁶ CNA News, 《中共 20 大》習近平報告【完整版】: 提一中原則與九二共識 [“ХКН-ын 20-р Бүгд хурал, Ши Жиньпин-ий бүрэн илтгэл ‘Нэг Хятад’ зарчим болон ‘98 зөвшилцөл’-ийг өргөн барив”], 2022 оны 10-р сарын 16. [《中共 20 大》習近平報告【完整版】: 提一中原則與九二共識 | 遠見雜誌 \(gvm.com.tw\)](https://www.gvm.com.tw/)

¹⁷ Taiwan Relations Act [Тайваньтай харилцах акт], March 24, 1979. [H.R.2479 - 96th Congress \(1979-1980\): Taiwan Relations Act | Congress.gov | Library of Congress](https://www.hrw.org/document/1979/03/24/taiwan-relations-act)

¹⁸ Commander Michael Dahm, U.S. Navy (Retired), “China’s Desert Storm Education” [“Хятадын ‘Цөлийн шуурга’-ны боловсрол”], March 2021. [China's Desert Storm Education | Proceedings - March 2021 Vol. 147/3/1,417 \(usni.org\)](https://www.usni.org/China's-Desert-Storm-Education-Proceedings-March-2021-Vol-147-3-1-417)

“Дайны 3 номлол”-ын товч агуулга нь орчин үеийн хэвлэл мэдээллийн олон талт арга, хэлбэр, дотоод, гадаадын холбогдох эрх зүйн орчныг ашиглан эсрэг талд онолын болон сэтгэлзүйн дайралт үзүүлж, уг үйл ажиллагаандаа хууль ёсны зөвтгөл олж авах байлдааны арга ажиллагаа юм.²¹ Энэ нь Хятадын ардын чөлөөлөх армийн улс төр, үзэл суртлын гол номлол болохын зэрэгцээ Зян Земинь-ээс хойш түүний агуулгыг улам өргөтгөн, зэвсэгт хүчин, аюулгүй байдлыг хамгаалах бусад байгууллага, тэдгээрийн харьяа нэгжүүдээс Тайваньд чиглэсэн бодлого, үйл ажиллагаанд баримтлах гол удирдамж болжээ.

Ши Жиньпин-ий эхлүүлсэн Хятадын ардын чөлөөлөх армийн шинэчлэлийн хүрээнд 2015 онд Цэргийн төв хорооны шууд харьяанд “Стратегийн дэмжлэг үзүүлэх хүчин”-ийг Сансар, Интернэт, Электрон, Цэргийн тагнуулын хэлтсийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан нь “Дайны 3 номлол”-ыг армийн тогтолцоонд нэвтрүүлэхэд томоохон түлхэц өгөв. Стратегийн дэмжлэг үзүүлэх хүчин сансар, интернэт, электрон болон сэтгэлзүй зэрэг биет бус орон зайн талбарт Хятадын ардын чөлөөлөх армийн агаар, тэнгис, хуурай зам болон пуужинт цэргийн хүчинд дэмжлэг үзүүлэх буюу байлдааны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй бүтэц юм.²² “Дайны 3 номлол”-ын бүрэлдэхүүн болох Сэтгэлзүйн дайныг Стратегийн дэмжлэг үзүүлэх хүчин хариуцах бол Онолын дайныг Цэргийн төв зөвлөлийн Улс төрийн хэлтэс, Эрх зүйн дайныг Цэргийн төв зөвлөлийн Улс төр, хуулийн хэлтэс хариуцан хэрэгжүүлнэ.²³

²³ 陳津萍, [習近平軍改前後「三戰」組織架構轉變研析], 頁 54.

“Дайны 3 номлол”-ын үндсэн агуулга

“Дайны 3 номлол” нь Онолын дайн, Эрх зүйн дайн болон Сэтгэлзүйн дайн гэсэн тус тусын ач холбогдол, харилцан нөлөөлөл бүхий цогц ойлголт юм. Түүний үзэл баримтлал нь орчин үеийн өндөр технологи, мэдээллийн эринд хэрхэн ялалт байгуулах тухай стратегийг агуулна. “Дайны 3 номлол”-ын зорилт нь эсрэг талын нутаг дэвсгэрт цэргээ оруулахын өмнө өөрт таатай орчныг бүрдүүлэх; эсвэл цэргийн хүч ашиглахгүйгээр эсрэг талаа буулган авахад оршино.

Хятадын Цэргийн шинжлэх ухааны академийн Улс төр судлалын хүрээлэнгийн дэд захирал Гун Фанбинь “Дайны 3 номлол”-ыг тодорхойлохдоо, “Энэ нь бүх төрлийн эх үүсвэрийг нэгтгэн, улс төр, үзэл суртал, оюун санаа, сэтгэл зүй, эрх зүй зэрэг талбарт эсрэг талдаа довтолгоо хийж зорилгодоо хүрэх байлдааны бус хэлбэр юм. Энэ нь цэргийн хүч хэрэглэхийн өмнө, цэргийн хүч хэрэглэх явцад болон түүний хойно үргэлжлэх шинжтэй буюу бага хүчээр их ялалтад хүрэх, түүнчлэн байлдахгүйгээр эсрэг талаа буулган авах үйл ажиллагаа юм”²⁴ гэжээ.

“Хоёр эрэг”-ийн ард түмний хэл, соёл, түүх, шашин шүтлэг, амьдралын хэв маяг зэргийн адил төстэй байдал нь Эх газраас “Тайванийг өөртөө нэгтгэх” бодлого, үйл ажиллагаанд “Дайны 3 номлол”-ын арга тактик хамгийн боломжит хувилбар бөгөөд Тайваньд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэнэ.²⁵ “Дайны 3 номлол” нь Хятадын эрх баригчдаас мэдээлэл, сэтгэлзүйн талбарт тайвань иргэдийн үзэл санаа, нийгмийн сэтгэлзүйд нөлөөлөх үр дүнтэй, цогц арга хэмжээний онолын суурь болж байна. Өөрөөр хэлбэл, энэ нь Эх

газраас “Тайванийг өөртөө нэгтгэх” үндсэн зорилтыг хэрэгжүүлэх тактикийн номлол юм.

Судлаачдын дүгнэснээр, “Эх газраас Тайваньд хэрэгжүүлж буй “хатуу хүч” буюу цэргийн заналхийлэл нь хятадын талын бодлого, үйл ажиллагааны зөвхөн нэг хэсэг. Тайванийн нийгэм, олон нийт улам бүр хагаралдан, эв нэгдлээ алдах бүрд “Дайны 3 номлол”-ын гүйцэтгэж буй үүрэг өсөн нэмэгдэнэ. Эсрэгээрээ Эх газрын “хатуу хүч” буюу цэргийн заналхийлэл улам багасна”²⁶ гэжээ. Эндээс үзвэл, Эх газраас Тайваньд хэрэгжүүлж бодлого, үйл ажиллагаа бүхэлдээ “Дайны 3 номлол”-ын хүрээнд идэвхжиж байна.

Тайванийн жишээн дээр Хятадын эрх зүйн дайны гол тактик нь “Нэг Хятад” зарчмыг олон улсад хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ болгох; “Тайвань бол БНХАУ-ын газар нутгийн салшгүй нэгэн хэсэг буюу түүний дотоод асуудал юм” гэх ойлголтыг дэлхийн улс орнуудад түгээхэд чиглэж байна.

2022 онд БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Тайванийг хариуцсан ажлын албанаас эрхлэн гаргасан “Цагаан ном”-д “‘Нэг Хятад’ бодлого нь олон улсын хамтын нийгэмлэгийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим бөгөөд олон улсын харилцааны суурь зарчмын адил дагаж мөрдөнө. . . НҮБ-ын

²⁴ 公方彬,「輿論戰心理戰法律戰正式成為中國軍隊的作戰樣式—」[“Онол, сэтгэл зүйн болон эрх зүйн дайн ХАЧА-ийн байлдааны хэлбэр болох нь”], 中國青年報 (2004 年 4 月 11 日). <http://news.beelink.com.cn/20040411/1560388.shtml>

²⁵ 郭盛哲,〈硬實力中的軟實力與銳實力：戰爭中的非軍事武力行動〉[“Хатуу хүчний доторхи зөөлөн хүч ба хурц хүч”]《復興崗學報》(台北市), 第 112 期, 國防大學政治作戰學院出版, 107 年 6 月, 頁 29-48.

²⁶ 元樂義,「和平崛起, 中共另覓對臺三戰」[“Энх тайвны сэргэн мандалт, ХКН-ын Тайвань дахь ‘3 дайн’-ыг ажиглах нь”], 中國時報 (2004 年 4 月 19 日). <http://www.future-china.org.tw/fcn-tw/200404/2004041901.htm>

Ерөнхий Ассамблейн 2758 тоот шийдвэр²⁷ нь ‘Нэг Хятад’ зарчим бол улс төрийн баримт бичиг болохыг илтгэх бөгөөд олон улсаас ноттой баталгаажуулсан эрх зүйн хүчин чадалтай буюу илтэд буруугаар тайлбарлахыг хориглоно. НҮБ-ын болон бусад бүрэн эрхт улс оролцож болох олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох

Гурав. Бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтэц

Хятадаас Тайванийг өөртөө нэгтгэх бодлого, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах дээд байгууллага нь 1993 оны 6-р сарын 25-ний өдөр ХКН-ын Төв хорооны харьяанд байгуулагдсан Тайваньд хэрэгжүүлэх ажлыг удирдах бүлэг бөгөөд түүний өдөр тутмын үйл ажиллагааг Тайванийг хариуцсан ажлын алба хариуцна.²⁹ Тайваньд хэрэгжүүлэх ажлыг удирдах бүлгийн дарга нь Ши Жиньпин, орлогч дарга нь Ван Хунин, нарийн бичгийн дарга нь Ван И юм. Энэхүү бүтцээс үзвэл ХКН-аас Тайванийг өөртөө нэгтгэх бодлого, үйл ажиллагаа нь нам, төрийн дээд удирдлагын шууд харьяанд, удирдлагаас өгсөн үүрэг чиглэл бүх салбарт хэлбэрэлтгүй хэрэгжих бүтэц бүрдсэнийг харж болно.

2017 онд хуралдсан ХКН-ын 19 дүгээр Бүгд хурал дээр Ши Жиньпин “Тайванийн асуудлыг

ямар нэгэн үндэслэл, шалтгаан, эсвэл эрх Тайваньд үгүй” гэжээ.²⁸ “Цагаан ном”-ын дээрх агуулга харьцангуй шинэ буюу Эрх зүйн дайны тактиктэй нягт уялдаж буй нь анхаарал татаж байна. Тухайлбал, 1993-2000 онд гаргасан “Цагаан ном”-д дээр дурдсан агуулга дурдагдаж байгаагүй болно.

шийдвэрлэх, Эх орноо нэгтгэх нь бүх хятад үндэстний хүсэл мөрөөдөл, язгуур ашиг сонирхол мөн”³⁰ хэмээн дурдсаны зэрэгцээ “Ши Жиньпин-ий шинэ эрин дэх Хятадын онцлогт социализмын үзэл санаа”-ны агуулгыг тодорхойлсон 14 зарчмыг дэвшүүлсэн. Уг зарчмын дотор “Нэг улс, Хоёр систем” болон “Эх орноо нэгтгэх” зорилт багтжээ.³¹ Эндээс үзвэл Тайванийг өөртөө нэгтгэх нь Хятадын эрх баригчдын “чухлын доторх чухал” зорилт буюу түүхэн үйл хэрэг хэмээн тодорхойлж болно.

Хятадын талаас мэдээлэл, сэтгэл зүйн талбарт Тайваньд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах гол байгууллага нь Төв хорооны Цэргийн төв зөвлөлийн харьяа нэгжүүд юм. Үүнд (Зураг 3):³²

²⁷ 1971 оны 10-р сарын 25-ны өдөр БНХАУ-ын шахалтаар НҮБ дахь Тайванийн суудлыг тус улсад шилжүүлсэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэр.

²⁸ БНХАУ-ын Цагаан ном, 台灣問題與新時代中國統一事業 [“Тайванийн асуудал ба шинэ эринд Хятад улсыг нэгтгэх үйл хэрэг”], 2022 оны 8-р сарын 10. [台灣問題與新時代中國統一事業 白皮書 中國政府網 \(www.gov.cn\)](http://www.gov.cn)


²⁹ ХКН-ын Төв хорооны Тайванийг хариуцсан ажлын алба, Төрийн зөвлөлийн Тайванийн асуудал эрхэлсэн алба, [机构设置 中共中央台湾工作办公室、国务院台湾事务办公室 \(gwyttb.gov.cn\)](http://gwyttb.gov.cn)

³⁰ 习近平在中国共产党第十九次全国代表大会上的报告 [“ХКН-ын 19 дүгээр Бүгд хурал дээр Ши Жиньпин-ий тавьсан илтгэл”], 2017 оны 10-р сарын 28. [习近平在中国共产党第十九次全国代表大会上的报告【13】--新闻报道--人民网 \(people.com.cn\)](http://people.com.cn)

³¹ 十四個堅持”基本方略 [“14 баримтлал-ын үндсэн чиглэл”], 2018 оны 8-р сарын 22. [【“十四個堅持”基本方略】--理論-人民網 \(people.com.cn\)](http://people.com.cn)

³² 陳津萍, [習近平軍改前後「三戰」組織架構轉變研析], 頁 54.

Зураг 3. Хятадын Цэргийн төв зөвлөлийн харьяа нэгжүүд.




Эх сурвалж: 陳津萍, [習近平軍改前後「三戰」組織架構轉變研析] [“Ши Жиньпин-ий цэргийн шинэчлэлийн өмнө ба хойнох ‘Дайны 3 номлол’-ын зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлтийн судалгаа”], 頁 54.

Дээр дурдсан нэгжүүд нь тус тусын чиглэлээр идэвхтэй ажиллахын зэрэгцээ хоорондын үйл ажиллагааг нягт уялдуулна. Цаашид бидний тухайлан судлах Сэтгэл зүйн дайны үйл ажиллагааг хариуцсан Стратегийн дэмжлэг үзүүлэх хүчний бүтцэд Нэгдсэн штаб, Интернэт, Сансар, Цэргийн тагнуул болон Электроникийн хэлтэс багтаж буй нь хятадын талд орчин үеийн цахим сүлжээ, мэдээлэл, электроникийн орчинд

мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, цахим орчинд мэдээлэл, сэтгэл зүйн дайралт хийх, олон нийтийн санаа бодлыг төөрөгдүүлэх, дарамт учруулах, уг зорилгоор технологийн дэвшилтэт арга, хэрэгслийг ашиглах өргөн боломжийг олгож байна. Стратегийн дэмжлэг үзүүлэх хүчний дотоод бүтцийг доорх зураг Үүнд (Зураг 4)-т харуулав:³³

Зураг 4. Стратегийн дэмжлэг үзүүлэх хүчний бүтэц.



Эх сурвалж: 王聖元, [中共戰略支援部隊之研究] [“Хятадын Стратегийн дэмжлэг үзүүлэх хүчний судалгаа”], 陸軍砲兵季刊, 第 191 期/2020 年 12 月, 頁 70.

³³ 王聖元, [中共戰略支援部隊之研究] [“Хятадын Стратегийн дэмжлэг үзүүлэх хүчний судалгаа”], 陸軍砲兵季刊, 第 191 期/2020 年 12 月, 頁 70. https://www.mnd.gov.tw/NewUpload/202012/p69-85%E4%B8%AD%E5%85%B1%E6%88%B0%E7%95%A5%E6%94%AF%E6%8F%B4%E9%83%A8%E9%9A%8A%E4%B9%8B%E7%A0%94%E7%A9%B6_152700.pdf

Эх газраас Тайваньд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа нь нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын дор улс төр, нийгэм, эдийн засаг, худалдаа, түүх, соёл, боловсрол, иргэний нийгэм, шинжлэх ухаан, технологи, хэвлэл мэдээлэл зэрэг өргөн салбарыг хамарсан, хоорондоо нягт уялдсан, цогц арга хэмжээний тогтолцоо юм.

Сүүлийн жилүүдэд хятадын тал Тайваньд чиглэсэн бодлогоо тодорхой бүлэг, нийгмийн давхаргад зориулж гаргах, түүнийг эдийн засгийн үр ашигтай уялдуулж, тайваньчуудын сэтгэлийг татах, урт хугацаанд үргэлжлэх шинжийг хадгалах зэрэг онцлогийг харгалзан тодорхойлох болсныг олон жишээгээр харуулж болно. Тухайлбал, 2014 онд Тайванийн асуудлыг хариуцсан ажлын албанаас “Гурван дунд”-ын бодлого (“Гурван дунд” гэдэгт Тайванийн **Дунд** баг аж ахуйн нэгж; **Дунд**, бага орлоготой иргэд; **Дунд**, өмнөд бүст оршин суугчдыг хамруулан ойлгоно)-ыг тодорхойлсон ч бодит байдал дээр Тайванийн суурь давхаргын иргэдийн үл ойлголцол, эсэргүүцэлтэй тулгарсан. Иймд тайвань хүүхэд, залуус ирээдүйн улс төрийн нөлөөлөгч хүч болохыг тооцоолж, “Гурван дунд” бодлогыг “Гурван дунд ба Залуу үе” агуулгаар өөрчлөн шинэчилжээ.³⁴

ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ши Жиньпин 2017 оны 10-р сарын 18-ны өдөр ХКН-ын 19 дүгээр Бүгд хурал дээр тавьсан илтгэлдээ, “Бид ‘Хоёр эрэг-Нэг гэр бүл’ үзэл санааг ямагт баримталж, Тайванийн нийгмийн тогтолцоо, иргэдийн амьдралын хэв маягийг хүндэтгэн, Эх газрын хөгжлийн боломжийг тайвань ахан дүүстэй дуртайяа хуваалцана. ‘Хоёр эрэг’-ийн

эдийн засаг, соёлын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан ашигтай байх зарчмыг хэрэгжүүлнэ. Улмаар тайваньчууд Эх газарт суралцах, ажил хөдөлмөр эрхлэх, шинэ бизнес эхлүүлэх зэрэгт Эх газрын иргэдтэй адил нөхцөлөөр хангаж, тайвань ахан дүүсийнхээ аз жаргал амьдралыг ахиулна”³⁵ гэжээ.

2019 оны 3-р сарын 11-ний өдөр Хятадын Улс төрөөр зөвлөлдөх зөвлөлийн гишүүн Жан Зөси, “Тайвань арлын дунд болон өмнөд хэсгийг чухалчлан, хөдөө тосгод, хот дүүрэг, тариачид, загасчид, өтгөс, эмэгтэйчүүд зэрэг суурь давхаргын хамтын ажиллагааны сувгийг өргөжүүлнэ. ‘Хоёр эрэг’-ийн харилцааны ирээдүй бол залуу үе юм. Тайвань залуус Эх газарт очиж суралцах, ажиллах сонирхол тогтмол нэмэгдэж буйг судалгаа харуулж байна. Иймд залуусын хамтын ажиллагааг үргэлжлүүлэн идэвхжүүлэхийг санал болгож байна” гэжээ. Энэхүү илтгэлээс үүдэн “Гурван дунд ба Залуу үе” бодлогыг “Нэг үе ба Нэг шугам” хэмээн шинэчилсэн хэмээн үздэг ч агуулгын хувьд онцын ялгаа байхгүй.³⁶

Хятадын эрх баригчдаас дэвшүүлж буй дээр дурдсан бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ авсны дотор “31 зүйлт”, “26 зүйлт”, “22 зүйлт” хөтөлбөрүүд багтаж байна. Тухайлбал, Төрийн зөвлөлийн Тайванийг хариуцсан ажлын албанаас 2018, 2019, 2021 онуудад зарласан “Хоёр эргийн эдийн засаг, соёлын харилцаа, хамтын ажиллагааны (31 зүйлт) хөтөлбөр”³⁷, “Хоёр эргийн эдийн засаг, соёлын харилцаа, хамтын ажиллагааны (26 зүйлт)

³⁴ 洪銘德, 黃恩浩, [中共統戰工作之研究：以對台社會基層統戰為例] [“Хятадын нэгдсэн фронтын судалгаа: Тайванийн нийгмийн үндсэн давхрагад чиглэсэн ажлыг жишээ болгов”], 復興崗學報 民 111 年 6 月, 120 期, 頁 56-57. [中共統戰工作之研究：以對台社會基層統戰為例 \(1\).pdf](#)

³⁵ 习近平在中国共产党第十九次全国代表大会上的报告 (全文) [“ХКН-ын 19 дүгээр Бүгд хуралд тавьсан Ши Жиньпин-ий бүрэн илтгэл”], 2017 оны 11-р сарын 3. [习近平在中国共产党第十九次全国代表大会上的报告 \(全文\)
Full text of Xi Jinping's report at 19th CPC National Congress - China.org.cn](#)

³⁶ 洪銘德, 黃恩浩, [中共統戰工作之研究：以對台社會基層統戰為例], 復興崗學報 民 111 年 6 月, 120 期, 頁 58.

³⁷ 关于印发《关于促进两岸经济文化交流合作的若干措施》的通知 [“Хоёр эргийн эдийн засаг, соёлын солилцоо, хамтын ажиллагааг ахиулах хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай мэдэгдэл”], [中共中央台湾工作办公室、国务院台湾事务办公室 \(gwytb.gov.cn\)](#)

хөтөлбөр”³⁸, “Хөдөө аж ахуй, ойн салбарын (22 зүйлт) хөтөлбөр”³⁹-үүдийг дурдаж болно. Дээрх хөтөлбөрүүдийн нийтлэг тал нь (а) “Хоёр эрэг”-ийн хоорондын холбоо, харилцааны дэд бүтцийг байгуулах буюу “Холбох”; (б) Тайваньчуудад эдийн засгийн үр ашигтай нөхцөл байдлыг амлах буюу “Өөртөө татах”; (в) Ахан дүүсийн харилцааг гүнзгийрүүлэх буюу “Дотносох” арга хэрэгслээр дамжин хэрэгжих бөгөөд зорилго нь “Тайванийг өөртөө нэгтгэх”-д чиглэнэ.⁴⁰

Хэдийгээр Эх газраас Тайваньд чиглэсэн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг зарлан хэрэгжүүлж буй ч бодит байдал дээр тэдгээрт тодорхой асуудал, бэрхшээл тулгарч буйг судлаачид онцолж байна. Тухайлбал,

1) Эх газраас Тайваньд хэрэгжүүлж буй нийгэм, эдийн засаг, соёлын хөтөлбөрүүд нь улс төрийн зорилгыг гол болгосон. Эх газрын ямар ч хөтөлбөр “Нэг Хятад” буюу “Тайванийн тусгаар тогтнол”-ын эсрэг бөгөөд Тайванийг энх тайвнаар өөртөө нэгтгэх зорилтод чиглэж байна. Иймд дурдсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга зам нь нийгэм, эдийн засаг, соёлын солилцоог ахиулах гэхээсээ илүү улс төрийн тугийг өндөрт мандуулахыг чухалчилж байна;

Дөрөв. Хятадаас Тайваньд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны чиглэл (кейс судалгаа)

Эх газраас Тайваньд хэрэгжүүлж буй гол бодлогын шинж чанартай үйл явдлыг дээр дурдсан бол дараах хэсэгт түүний бодит байдал дээрх хэрэгжилтийн талаар нарийвчлан авч үзье.

2) Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд Хятадын нам, төрийн байгууллагуудын оролцоо, ялгаатай эрх ашиг хөндөгдөх тул тэдгээрийн харилцан ажиллагаа хамгийн чухал. Тухайлбал, Тайванийг хариуцсан ажлын алба, Хөгжил шинэтгэлийн хороо зэрэг 31 яам, агентлаг үүнд багтаж байна. Иймд хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэхийн тулд тэдгээр нь үр дүнтэй уялдан ажиллаж чадах эсэх нь асуудалтай.⁴¹

Сиамэнь их сургуулийн профессор Лю Гуошэнь энэ талаар, “Хөтөлбөрөөр ‘Хоёр эрэг’-ийн хамтын ажиллагааг ахиулах олон арга хэмжээг дэвшүүлж буй нь Эх газрын хувьд удирдлага, зохион байгуулалтын маш том сорилтыг авчирна. Эх газар ирээдүйд ямар арга, хэлбэрээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутгийн засгийн газрууд түүнийг дагаж мөрдөх эсэх нь ихээхэн анхаарал татаж байна. Эс бөгөөс бусад хөтөлбөрүүдийн адил ‘аман ашиг’ болж үлдэх буюу ‘Сэтгэл зүйн’ дайн, ‘Цаасан дайн’ болж хувирах магадлалтай” гэжээ.⁴² Эндээс үзвэл, дээрх хөтөлбөрүүд нь тухайн зорилтоо хэрэгжүүлэхээс илүүтэй “Тайванийг нэгтгэх” улс төрийн зорилгод үйлчилж буйг харж болохоор байна.

Ингэхдээ Эх газраас хэвлэл мэдээллийн арга хэрэгслээр нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх зорилго бүхий бодит жишээнд тулгуурлах болно. Үүнд:

³⁸ 关于进一步促进两岸经济文化交流合作的若干措施(全文) [“Хоёр эргийн эдийн засаг, соёлын солилцоо, хамтын ажиллагааг ахиулах хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай мэдэгдэл (бүрэн эх)”, 2019 оны 11-р сарын 4. [关于进一步促进两岸经济文化交流合作的若干措施\(全文\) 新浪新闻 \(sina.com.cn\)](http://www.sina.com.cn)

³⁹ 國台辦發言人介紹“農林 22 條措施”和其三大特點 [“Тайванийн хэрэг эрхлэх алба: 22 зүйлт хөтөлбөр ба 3 чухал онцлог”, 2019 оны 11-р сар. [國台辦發言人介紹“農林 22 條措施”和其三大特點--台灣頻道--人民網 \(people.com.cn\)](http://www.people.com.cn)

⁴⁰ 陳鈺馥, 〈習彈「通惠情」 陸委會: 統戰大於實質〉 [“Эх газрын хороо: Нэгдсэн фронтын мөн чанар”], 2021 оны 7-р сарын 5. [《自由時報》 https://news.ltn.com.tw/news/politics/paper/1458783](https://news.ltn.com.tw/news/politics/paper/1458783)

⁴¹ 黃奕維, [由大陸「對臺 31 項措施」 觀察其對臺政策] [“Эх газраас Тайваньд хэрэгжүүлэх 31 зүйлт хөтөлбөрийн хяналт ба Тайвань дахь бодлого”], PROSPECT & EXPLORATION 第 16 卷, 第 4 期, 中華民國 107 年 4 月, 頁 38. https://www.mjib.gov.tw/FileUploads/eBooks/f344686292a247a1b9082d24096c7886/Section_file/70fabe81cdcd490688942707ebccb38b.pdf

⁴² 黃奕維, [由大陸「對臺 31 項措施」 觀察其對臺政策], 頁 38.

Тайванийн тусгаар тогтнолыг дэмжигчдийн эсрэг

Эх газраас Тайванийн тусгаар тогтнолыг дэмжигчдийн эсрэг авч буй гол арга хэмжээнүүдийн нэг 2005 оны 3-р сарын 14-ний өдөр Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлаас баталсан “Салан тусгаарлалтын эсрэг хууль” юм. Уг хуулийн Нэгдүгээр зүйлд, “Тайванийн тусгаар тогтнолыг дэмжигчдийн эсрэг буюу тэдгээрийн эх орноо хагалган бутаргах үйл ажиллагааг хязгаарлах, эх орноо энх тайвнаар нэгтгэх явдлыг ахиулах, Тайвань хоолойн энх тайван, тогтвортой байдал, улсын бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хятад үндэстний язгуур эрх ашгийг хамгаалах зорилгоор Үндсэн хуульд үндэслэн энэхүү хуулийг батлав” хэмээн тусгажээ.⁴³ Уг хууль бүхэлдээ Тайванийн тусгаар тогтнолын эсрэг чиглэсэн бөгөөд түүнийг зөрчигчдөд хатуу шийтгэл хүлээлгэхээр зохицуулсан байна. Тухайлбал, мөн хуулийн 9-р зүйлд, “Тус хуулийн дагуу энх тайвны бус буюу бусад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх үед төрөөс энгийн тайвань иргэд, Тайваньд дахь гадаад иргэдийн амь нас, эд хөрөнгийн аюулгүй байдал, бусад зүй ёсны эрх ашгийг хамгаалж, хохирлыг багасгах боломжит арга хэмжээг авна. Түүнчлэн төрөөс хуулийн дагуу Хятад дахь тайвань иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаална”⁴⁴ гэсэн нь Хятадын эрх баригчид шаардлагатай тохиолдолд Тайваньд цэргийн хүч хэрэглэхээс үл буцахаа дахин нотлон харуулсан үйлдэл байв.

2020 оны 1-р сард Тайванийн Ерөнхийлөгч асан Цай Инвэнь мэдээллийн ВВС агентлагийн сурвалжлагчид өгсөн ярилцлагадаа, “Бид тусгаар тогтнолоо зарлах шаардлагагүй, учир нь бид угаасаа тусгаар улс”⁴⁵ гэсэн бол 2024 оны 5-р сарын 20-ны өдөр түүний халааг авч Ерөнхийлөгчөөр сонгогдсон Лай Циндө, “Тайванийн ирээдүйг зөвхөн 23 сая тайвань иргэн шийднэ. . . Тайвань, Эх газар ямар ч харилцан хамааралгүй”⁴⁶ хэмээн мэдэгдсэн. Харин Эх газрын Тайванийн асуудал хариуцсан ажлын албаны хэвлэлийн төлөөлөгч Чэнь Биньхуа, “Лай Циндө “Тайванийн тусгаар тогтнол”-ыг хатуу баримтлахаа мэдэгдэж, салан тусгаарлах үзлийг сурталчилж, “Хоёр эрэг”-ийн харилцаанд сөв суулгахыг явдлыг дэвэргэн, гаднын хүчинтэй хуйвалдахыг санаархаж байна. Энэ нь түүний “Тайванийг тусгаар тогтнолыг дэмжигч” байр суурийг харуулав. “Тайванийн тусгаар тогтнол”-ыг дэмжигч аливаа оролдлогыг Эх газар хүлцэн тэвчихгүй”⁴⁷ гэжээ.

Эх газраас ямар ч тохиолдолд “Тайванийн тусгаар тогтнол”-ыг дэмжихгүй гэдгийг удаа дараа мэдэгдэхийн зэрэгцээ “шаардлагатай тохиолдолд цэргийн хүч хэрэглэхээс татгалзахгүй” байр суурийг баримталж ирсэн. Энэ тохиолдолд “Тайванийн тусгаар тогтнол”-ыг дэмжигчдийн зориг зүрхийг мохоох буюу хэрэв тусгаар тогтнолын байр сууринаасаа ухрахгүй бол “Хятадын ардын чөлөөлөх арми Тайваньд халдан ороход хэзээд бэлэн, ганц цохилтоор Тайванийг

⁴³ 反分裂國家法, 第一條 [Салан тусгаарлалтын эсрэг хууль, 1-р зүйл], 2005 оны 3-р сарын 14. 反分裂國家法 (主席令第三十四號) (www.gov.cn)

⁴⁴ 反分裂國家法, 第九條 [Салан тусгаарлалтын эсрэг хууль, 9-р зүйл].

⁴⁵ 蔡英文: 我們不需要宣布獨立 因為已經是獨立國家 [“Цай Инвэнь: Бид тусгаар тогтнолоо зарлах шаардлагагүй, учир нь бид аль хэдийн тусгаар улс”], 2020 оны 1-р сарын 15. 蔡英文: 我們不需要宣布獨立 因為已經是獨立國家 - 政治 - 中時 (chinatimes.com)

⁴⁶ 520 就職演說 賴總統: 3 方向推動台灣發展 [“Лай Циндө: Тайванийн хөгжлийг 3 чиглэлээр урагшлуулна”], 2024 оны 5-р сарын 20. 520 就職演說 賴總統: 3 方向推動台灣發展 | 賴清德就任總統 | 要聞 | 聯合新聞網 (udn.com)

⁴⁷ 看完賴清德 520 演說 陸國台辦回應了: 絕不容忍台獨行徑 [“Эх газрын Тайванийн асуудал эрхэлсэн алба: Тайванийн тусгаар тогтнолыг хэзээ ч үл хүлээн зөвшөөрнө”], 看完賴清德 520 演說 陸國台辦回應了: 絕不容忍台獨行徑 - 兩岸 - 中時 (chinatimes.com)

Дээрх зорилгоор Хятадын ардын чөлөөлөх арми тодорхой давтамжтайгаар болон онцгой үйл явдлыг тохиолдуулан, тухайлбал Тайванийн үндэсний баярын өдөр, БНХАУ байгуулагдсаны ойн баяр, тайванийн талаас эрс хатуу мэдэгдэл хийх үеэр, гадаадын тэр дундаа АНУ-ын албан ёсны болон албан бус төлөөлөгчид Тайваньд айлчлах үеэр томоохон цэргийн сургуулилт хийх, Тайванийн далай, агаарын хяналтын зайд байлдааны онгоцоор халдах зэргээр дарамт үзүүлдэг. Ихэнх тохиолдолд хятадын тал эдгээр үйлдлээ олон нийтэд урьдчилан зарлаж, ил тодоор явуулдаг байна. Тухайлбал, 2022 онд АНУ-ын Төлөөлөгчдийн тэнхимийн тэргүүн Нэнси Пелосийн Тайвань дахь айлчлалыг тохиолдуулж Хятадын ардын чөлөөлөх арми 4 хоногийн цэргийн сургуулилт зохион байгуулсан. Мөн үеэр Тайванийн дотоод дахь хятадын талыг баримтлагч хэвлэл мэдээллийн хэрэгслүүд “Эх газар Тайваньд халдан довтлох” тухай хуурамч мэдээллийг цацаж,

Технологийн хөгжилтэй уялдан олон нийтийн цахим сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл солилцох, дамжуулах өргөн боломж нь хятадын талаас түүнийг идэвхтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлж байна.

тэр нь зарим иргэдийн сэтгэл зүйд нөлөөлж, дайн болохоос өмнө амжиж хүнсний нөөц бэлтгэхээр дэлгүүрт хиймэл дараалал үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байв.⁴⁸ 2024 оны 5-р сарын 20-ны өдөр Тайванийн шинээр сонгогдсон Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын үеэр хятадын тал мөн сарын 23-24-нд хуурай зам, тэнгис, агаар, пуужинт цэргийн хүчнийг хамруулсан “Холбоотны сэлэм-2024(А)” сургуулилтыг Тайванийн мэдлийн Зиньмэнь, Мазу зэрэг арлын ойролцоо хийсэн⁴⁹ бол 2024 оны 10-р сарын 10-ны өдөр Тайванийн үндэсний баярын өдрөөр Ерөнхийлөгч Лай Циндө-н хэлсэн үгтэй холбогдуулж мөн сарын 14-нд Тайвань арлыг бүсэлсэн “Холбоотны сэлэм-2024(В)” цэргийн сургуулилтыг дахин хийсэн байна. Хятадын талын мэдэгдэж буйгаар, “энэ удаагийн цэргийн сургуулалт нь Тайванийн салан тусгаарлагчдын эсрэг авч буй хатуу арга хэмжээ бөгөөд улс орныхоо бүрэн бүтэн байдлын төлөө хэрэгжүүлж буй зайлиггүй үйлдэл” байжээ.⁵⁰

Volume 48 | No 118 | 2025

Хятадын талын цахим халдлага, хуурамч мэдээлэл тарааж буй үйл ажиллагааны нэг онцлог нь Стратегийн дэмжлэг үзүүлэх хүчин доороо Тагнуул болон Цахим халдлагын бүлгийг нэгтгэсэн явдал юм. Энэ нь тус хүчин хүн эх сурвалжийн тагнуулын ажлын үр дүнг цахим платформтай уялдуулах буюу цахим эх сурвалжаас олзолсон мэдээллийг

мэргэжилтнүүдийн хүчээр боловсруулан, эргээд нөхцөл байдлыг гуйвуулсан мэдээлэл тарааж буйгаас харагдаж байна.⁵² Хятадын ардын чөлөөлөх армийн Стратегийн дэмжлэг үзүүлэх хүчнээс мэдээллийн орчинд голчлон явуулдаг ажиллагааг судлаачид дараах байдлаар (Зураг 5) тодорхойлсон байна.⁵³

Зураг 5. Стратегийн дэмжлэг үзүүлэх хүчний мэдээллийн орчинд явуулдаг үйл ажиллагаа

Ажиллагааны үе	Объект	Үе шат	Мэдээллийн хэлбэр	Арга хэрэгсэл	Зорилго
Энгийн үед	Эсрэг талын олон нийт	- Үндэсний стратеги; - Цэргийн стратеги; - Байлдааны тактик.	1. Бодит мэдээлэл; 2. Хуурамч мэдээлэл; 3. Хуурамч болон бодит мэдээллийн холимог.	- Санаа бодлыг удирдах; - Цахим халдлага.	1. Эсрэг талын дотор зөрчил үүсгэх; 2. Өөрийн улсын дотоод тогтвортой байдлыг хамгаалах; 3. Олон улсын дэмжлэгийг авах.
	Өөрийн талын олон нийт				
	Олон улс				
Дайны үед	Эсрэг талын лидерүүд	- Үндэсний стратеги; - Цэргийн стратеги; - Байлдааны тактик.	1. Бодит мэдээлэл; 2. Хуурамч мэдээлэл; 3. Хуурамч болон бодит мэдээллийн холимог.	- Когнитив; - Электрон халдлага; - Цахим халдлага.	1. Эсрэг талын командлагчдаар буруу шийдвэр гаргах; 2. Байлдааны талбарт сэтгэл зүйн дарамт үүсгэх; 3. Эсрэг талын олон нийтээс дайныг эсэргүүцэх хандлагыг дэврээх.
	Дайны талбар дахь анги нэгтгэл				
	Эсрэг талын олон нийт				

Эх сурвалж: 林正愷, [中共認知戰操作策略與我國因應作為] [“Хятадын ухамсрын дайны бодлого, үйл ажиллагаа ба манай улсын хариу үйлдэл”], National Defense Journal Vol.36, No.1, MAR 2021, 頁 10.

⁵² 林穎佑, [中共戰略支援部隊的任務與規模] [“Хятадын стратегийн дэмжлэг үзүүлэх хүчний чиг үүрэг, хамрах хүрээ”], PROSPECT & EXPLORATION 第 15 卷 第 10 期 中華民國 106 年 10 月, 頁 109. https://www.mjib.gov.tw/FileUploads/eBooks/1a78a95eb4ab49f28342f0cb6b25ba93/Section_file/2898ca28058242a9849c0147c92fa511.pdf

⁵³ 林正愷, [中共認知戰操作策略與我國因應作為] [“Хятадын ухамсрын дайны бодлого, үйл ажиллагаа ба манай улсын хариу үйлдэл”], National Defense Journal Vol.36, No.1, MAR 2021, 頁 10. *001-022 網頁用 350062.pdf

Хятадын ардын чөлөөлөх армиас гадна Улсыг аюулаас хамгаалах яам болон Нийгмийг хамгаалах яам, тэдгээрийн харьяа нэгжүүд цахим мэдээллийн орчинд гадагш чиглэсэн халдлагыг өргөн цар хүрээтэй хэрэгжүүлж буйг судлаачид онцолж байна. 2013 оноос хойш хятадын талын энэ чиглэлийн үйл ажиллагаа эрс идэвхэжсэн нь дээр дурдсан Хятадын ардын чөлөөлөх армид шинэчлэл хийсэн цаг хугацаатай үндсэндээ давхцадаг. Зарим судлаачийн үзэж буйгаар, Хятадын Улсыг аюулаас хамгаалах яам болон Нийгмийг аюулаас хамгаалах яамнаас тухайлсан нийгмийн орчинд цахим халдлага зохион байгуулах, цахим платформуор дамжуулж нөлөөллийн үйл ажиллагаа явуулахдаа энэ чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй гэрээгээр хамтран ажиллах, эсвэл шинээр бий болгох зэрэг байж болох бүхий л арга замыг өргөнөөр ашигладаг. Тухайлбал, 2013-2023 оны хооронд хятадын тусгай чиг үүргийн байгууллагуудтай хамтран ажилласан цахим үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж буюу хакеруудын тоо 4000-д хүрчээ.⁵⁴ Эдгээр нь ихэвчлэн хятадын тусгай чиг үүргийн байгууллагуудтай нууц гэрээ байгуулж, өөрсдийн *IP* хаяг, хуулийн бүртгэл, байршлыг нууж, цахим платформд хуурамч мэдээлэл цацах буюу тухайн объектын компьютерын системд хакерын халдлага хийж, мэдээлэл цуглуулдаг.

2023 оны 12-р сарын 3-ны өдөр Тайбэй хотын захиргааны гадна *“Цагаач энэтхэг ажилчдыг Тайваньд оруулж ирэхийн эсрэг”* зохион байгуулсан тайвань залуусын жагсаал нь хятадын талын дээрх үйл ажиллагааны тод жишээ болно. 2023 оны 11-р сарын 13-ны өдөр *Dcard* цахим сайтад *“100 мянган энэтхэг ажилчдыг Тайваньд*

оруулж ирэх” тухай хуурамч мэдээлэл тавигдсанаар эхэлсэн сошиал маргаан залуусын дунд тархаж, улмаар 12-р сарын 3-ны өдрийн эсэргүүцлийн жагсаал болон хувирчээ. Сошиал хэлэлцүүлгийн үеэр *“Эх газрын хятадуудын оронд яагаад энэтхэгчүүдтэй хамтран ажиллах ёстой гэж?”*, *“Энэтхэгчүүд тайваньчуудын ажлын байрыг булаах нь”*, *“Хүчингийн хэрэг улам ихэснэ”* зэрэг нийтэд буруу ойлголт төрүүлэх, айдаст автуулах гарчиг бүхий мэдээлэл ар араасаа хөвөрсөн нь дээрх эсэргүүцлийн цуглаанд оролцогчдын хүрээг тэлэхэд хүчтэй нөлөөлжээ. Мэргэжилтнүүд уг хуурамч мэдээллийн цахим ул мөрийг хайхад түүнийг анх түгээсэн вэбсайт, мэдээний агуулга дахь үг хэллэг зэрэг нь тайваньчуудын өдөр тутмын хэллэгээс өөр буюу үндсэндээ Эх газраас зохион байгуулсан арга хэмжээ болох нь тогтоогдсон байна.⁵⁵

Хятадаас Тайваньд чиглэсэн тодорхой бодлогоо зарлан хэрэгжүүлэх, сурталчлах, Тайванийн олон нийтэд хүргэх, иргэдийн сэтгэл зүйд нөлөөлөхдөө тухай мэдээллийн сэдэв, агуулга, нэвтрүүлэх суваг зэрэгт онцгой ач холбогдол өгдөг. Тухайлбал, өмнө дурдсан *“31 зүйлт”* хөтөлбөрийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацахдаа *“Тайвань ахан дүүс”*, *“Залуу үе”*, *“Тайвань бизнес эрхлэгчид”*, *“Хөгжил”*, *“Хамтын ажиллагаа”* зэргийг түлхүүр үгс болгожээ. Эндээс хятадын тал Тайванийн залуу үе, бизнес эрхлэгчдэд бодлогоо чиглүүлж буйг харж болно. Агуулга талаас нь авч үзвэл, тайваньчуудад үндэстний хувьд сэтгэгдэл төрүүлэхээр *“Ахан дүүс”*, *“Соёлын ижилсэл”*, *“Үндэстний дотносол”*, *“Эв нэгдэл”* зэрэг үг хэллэгийг түлхүү ашиглаж

⁵⁴ 日本 NHK 年度重磅纪录片「追踪中国泄露的文件」日本记者用半年時間，走訪 7 個國家，找寻 577 份泄密文件之真相。这些文件均涉及中国政军民三界，集体进行跨境网络攻击及舆论操控的「认知战」行为 [“Хятадын талаас задруулсан баримт бичгүүдийг нэхэн сурвалжлах нь”]. YouTube video, 22:08, October 21, 2024. [日本 NHK 年度重磅纪录片「追踪中国泄露的文件」日本记者用半年時間，走訪 7 個國家，找寻 577 份泄密文件之真相。这些文件均涉及中国政军民三界，集体进行跨境网络攻击及舆论操控的「认知战」行为。\(youtube.com\)](#)

⁵⁵ 日本 NHK 年度重磅纪录片「追踪中国泄露的文件」日本记者用半年時間，走訪 7 個國家，找寻 577 份泄密文件之真相。这些文件均涉及中国政军民三界，集体进行跨境网络攻击及舆论操控的「认知战」行为 [“Хятадын талаас задруулсан баримт бичгүүдийг нэхэн сурвалжлах нь”]. YouTube video, 43:47, October 21, 2024.

буй нь далдуур нөлөөлөл явуулж буйн хэлбэр юм.
56

Олон улсын “Freedom House”-ийн 2018 онд гаргасан “Дэлхийн улс орнуудын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаарх тайлан”-д дурдсанаар жил бүр Тайванийн хэвлэл, мэдээллийн салбар дахь Эх газрын нөлөө улам бүр нэмэгдэж байна. Тухайлбал, Эх газрын эрх баригчдын дургүйцлийг төрүүлэхүйц тодорхой мэдээлэл нийтлэх, түгээх, Хятадын талаарх чөлөөт байр суурь, үзэл бодлоо илэрхийлэхээс зайлсхийх явдал тасрахгүй байна. Томоохон хэвлэл, мэдээллийн толгой компаниуд Эх газраас хөрөнгө оруулалт татахын зэрэгцээ түүний зах зээлээс хараат байгаа нь үүнд давхар нөлөөлдөг. Энэ нь зарим хэвлэл, мэдээллийн агентлаг Хятадын хөгжил, цэцэглэлт, үзэл санааны талаарх суртал ухуулгын мэдээллийг санаатай болон санамсаргүй байдлаар түгээн дэлгэрүүлэхэд хүргэж байна. Тодруулбал, 2018 оны Тайванийн орон нутгийн сонгуулийн үеэр Эх газраас санхүүгийн дэмжлэг авсан зарим хэвлэл, мэдээллийн байгууллага, олон нийтийн санал бодлыг тандан судалдаг компаниуд сонгуульд нөлөөлөхүйц хуурам санал асуулгын үр дүн, нөхцөл байдлыг гуйвуулсан мэдээлэл цацсан явдал гарч байв.⁵⁷

Сүүлийн жилүүдэд Хятадын эрх баригчид олон нийтийн цахим сүлжээ, хэвлэл, мэдээллийн салбарт нөлөө бүхий урлаг, соёлын одод, улс төр, нийгмийн зүтгэлтнүүдийг өөрсдийн суртал ухуулгад өргөнөөр ашиглаж байна. Тэдгээрийн *Facebook, Line, Youtube, Instagram* зэрэгт олон сая дагагчтай, олон нийт, тэр дундаа хүүхэд залууст хүчтэй нөлөөлөхүйц байдал нь Эх газрын анхаарлыг татдаг. 2024 оны 6-р сарын 12-ны өдөр

Threads-т гарсан мэдээллээр, “Эх газар Тайванийн 10 бүлэг социал нөлөөлөгчдийг Хятадад урьж нэвтрүүлэг хийх” саналыг тавьсан байна.⁵⁸ Хятадын талаас социал нөлөөлөгчдийн зочид буудал, замын зардлыг даах, нэвтрүүлгийн агуулгаас улс төрийн сэдвийг хасах зэрэг нөхцөлийг тавихын зэрэгцээ уг санаачилгын гол зорилго нь Хятадын хөгжил, цэцэглэлтийг тайваньчуудад сурталчлах явдал байв.

Түүнчлэн Тайванийн орон нутгийн иргэд, тэдгээрийн үзэл бодолд нөлөөлөгч гацаа, тосгодын удирдлагыг Эх газарт урих, хөдөө тосгодын иргэдийн хоорондоо мэдээлэл солилцдог *Facebook, Line* группт хуурамч мэдээлэл түгээх зэргээр нийгмийн суурь давхаргат чиглэсэн ажлыг өргөнөөр зохион байгуулж байна. 2017, 2018 онуудад дурдсан социал платформоор дамжуулан “Шашныг мөхөөж байна”, “Гуанси нисэх буудлын хэрэг”, “Илүүдэл гадилын татвар” зэрэг орон нутгийн тайвань иргэдийг Төв засгийн газартаа итгэл алдуулахад түлхсэн хуурамч мэдээллийг түгээж байв. Хятадын тал Тайванийн хөдөө, тосгодод бий болгосон тодорхой хүрээлэл, мэдээллийн платформыг ашиглан сонгуулийн үр дүн нөлөөлөх ажиллагаа явуулах болсон бөгөөд үүнд иргэдэд нөлөөтэй нийгмийн жижиг бүлгийн удирдлагууд багагүй дэмжлэг үзүүлж байна. Нийгмийн ийм жижиг бүлгийн удирдлагууд өөрсдөө мэдэлгүйгээр буюу “харанхуй”-гаар Хятадын бодлого, үйл ажиллагааг дэмжих, Эх газрын хуурамч мэдээлэл, үзэл суртал, эдийн

⁵⁶ 陳育正等, [由社群媒體的觀點論習近平主政後對臺 統戰策略對我國民眾的影響：以對臺 31 項措施為例] [“Ши Жиньпин эрх барьсанаас хойшхи нэгдсэн фронтын Тайвань дахь бодлого, нөлөөлөл: 31 зүйлт хөтөлбөрийн хэрэгжилт”], 中國大陸研究第 63 卷第 2 期, 頁 120. [陳育正 \(1\).pdf](#)

⁵⁷ 洪子傑、陳穎萱, [中國銳實力] [“Хятадын хурц (sharp) хүч”], (Батлан хамгаалах, аюулгүй байдал судлалын хүрээлэн, 2018 оны 12-р сар) 頁 67. <https://indsr.org.tw/uploads/indsr/files/202206/e3a60e10-a36a-4e11-82af-fc4e1ea58ede.pdf>

⁵⁸ 林乃絹, 中国传砸钱渗透台湾网红艺人圈 [“Хятад улс мөнгөөр Тайванийн социал оддын хүрээнд нэвтрч байна”], June 24, 2024. [中国传砸钱渗透台湾网红艺人圈\(图\) 中共 | 文化 | 统战 | 时评 | 林乃絹 | 看中国网 \(secretchina.com\)](#)

засгийн жижиг урхинд автах явдал нэмэгдэж байна.⁵⁹

Олон улс дахь Тайванийн нэр хүндийг унагах чиглэлд

Эх газрын төдийгүй Тайванийн эрх баригчдын хувьд олон улс дахь өөрсдийн байр суурийг бэхжүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх, тэдгээрийн дэмжлэгийг олж авах нь чухал ач холбогдолтой.

1971 оны 10-р сарын 25-ны өдөр НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2758 тоот шийдвэрээр⁶⁰ БНХАУ нь тус байгууллага дахь Тайванийн орыг эзлэн авснаас хойш олон улс дахь байр сууриа улам бэхжүүлж, Тайванийн олон улсын байгууллага дахь гишүүнчлэл, бусад улсуудтай тогтоосон дипломат харилцааг таслах зэрэг арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд дэлхийн улс орнууд ээлж дараалан Тайваньтай дипломат харилцаагаа тасалж, түүний оронд БНХАУ-тай дипломат харилцаа тогтоов. Хамгийн сүүлд буюу 2024 оны 1-р сарын 15-ны өдөр Номхон далайн арлын Науру улс “Нэг Хятад” зарчмыг хүлээн зөвшөөрч, Тайваньтай дипломат харилцаагаа таслан, БНХАУ-тай албан ёсоор дипломат харилцаа тогтоосноо мэдэгдэв.⁶¹ Ингэснээр Тайваньтай дипломат харилцаатай улсын тоо 11 болон буурав. Эдгээр улсын ихэнх нь Латин Америк, Номхон далайн арлын жижиг улсууд бөгөөд Эх газраас одоог хүртэл тэдгээрт шахалт үзүүлэх, эдийн засаг, худалдааны ашигтай нөхцөл амлах хэлбэрээр өөртөө татах бодлогыг хэрэгжүүлж байна.

БНХАУ-ын хувьд хоёр болон олон талт яриа хэлэлцээрээр дамжуулж, “Нэг Хятад” бодлого, зарчмын хүрээнд “Тайвань бол БНХАУ-ын саллигүй нэг хэсэг мөн” гэх мэдэгдлийг нөгөө талаар заавал хэлүүлдэг дипломат прецедент тогтоогоод удаж байна. Тодруулбал энэ нь хятадын талын эрх баригчид бусад улсад айлчлах, гадаад улсын төр, засгийн төлөөлөгчид Хятад улсад айлчлах үеэр заавал хэрэгждэг тогтсон хэм хэмжээ болжээ.

Хятадын талаас олон улсад чиглэсэн өөр нэг арга хэмжээ нь дотооддоо гаргасан бодлого, шийдвэр, эрх зүйн баримт бичгүүдийн нэршил, агуулгыг Хятадын өнцгөөр тайлбарлан таниулах явдал бөгөөд энэ нь тэдгээр баримт бичгүүдийн англи орчуулгаар дамжин илрэн гардаг. Тухайлбал, 2005 оны 3-р сарын 14-ний өдөр батлагдсан “Салан тусгаарлахын эсрэг хууль”⁶²-ийн англи хэл дээрх орчуулгыг “Anti-Secession Law” хэмээн тогтсон бол тайванийн талаас уг хуулийн нэршлийг “Anti-Separation Law” хэмээн ялгамжтай нэрлэдэг.⁶³ Хятадын талаас тодорхойлсон “Secession” гэх орчуулга нь “Эх газар болон Тайвань нь нэг улсад харьяалагдах буюу хууль зүйн хувьд нэгдмэл байдалд буйг далдуур илэрхийлж” буй бол тайванийн талаас дэвшүүлж буй “Separatism”-ын утга нь “угийн нэгдмэл байдлаас салж тусгаарласан, одоо

⁵⁹ 洪子傑、陳穎萱, [中國銳實力] [“Хятадын хурц (sharp) хүч”], (Батлан хамгаалах, аюулгүй байдал судлалын хүрээлэн, 2018 оны 12-р сар) 頁 66. <https://indsr.org.tw/uploads/indsr/files/202206/e3a60e10-a36a-4e11-82af-fc4e1ea58ede.pdf>

⁶⁰ 聯合國大會第 2758 號決議 [“НҮБ-ын Ерөнхий ассемблейн 2758 тоот шийдвэр”], [聯合國大會第 2758 號決議 - 維基百科, 自由的百科全書 \(wikipedia.org\)](https://zh.wikipedia.org/wiki/United_Nations_General_Assembly_Resolution_2758)

⁶¹ 外交部发言人就瑙鲁政府宣布同台湾“断交”、愿同中国复交答记者问 [“ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч Науру улс Тайваньтай харилцаагаа тасалсныг мэдэгдэв”], 2024 оны 1-р сарын 15. [外交部发言人就瑙鲁政府宣布同台湾“断交”、愿同中国复交答记者问 \(china-embassy.gov.cn\)](https://china-embassy.gov.cn/)

⁶² 反分裂國家法 [“Салан тусгаарлахын эсрэг хууль”], [反分裂國家法 \(主席令第三十四號\) \(www.gov.cn\)](http://www.gov.cn/)

⁶³ 羅俊宏, [中共對臺「三戰」策略運用之研析] [“Хятадаас Тайваньд хэрэгжүүлж буй ‘3 дайн’-ы бодлого, үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ”], 復興崗學報 民 94, 85 期, 頁 60. [85-03 copy.pdf](#), [中共對臺「三戰」策略運用之研析 | Airiti Library 華藝線上圖書館](#)

тусдаа *оришиж буй*”-г заасан агуулгатай. Өөрөөр хэлбэл, Хятадын “Салан тусгаарлахын эсрэг хууль”-ийн үзэл санаа нь “*Тайвань бол БНХАУ-ын салшгүй нэг хэсэг*” гэдгийг хууль зүйн утгаар томъёолсон төдийгүй олон улсад мөн ойлголтыг төрүүлэх зорилготой ажээ.

Олон улсын тавцанд Тайванийг ганцаардуулах чиглэлээр хэрэгжүүлж буй хятадын бодлого, үйл ажиллагаанд “Хятадын олон улс судлалын хүрээлэн (CIPS)”, “Хятадын нийгмийн шинжлэх ухааны академи (CASS)”, “Орчин үеийн дэлхий судлалын төв (CCCWS)” зэрэг бодлогын судалгаа,

тинк-танк, академик хүрээлэнгүүд идэвхтэй оролцдог. Тухайлбал, дурдсан судалгааны хүрээлэнгүүд олон улсын хуралд оролцох, мэдээлэл цуглуулах, боловсруулах, тараах, академик судалгааны үр дүнгээр “Нэг Хятад” бодлогыг нотлох, олон улсын судлаачдад нөлөөлөх зэрэг хэлбэрээр хятадын талд дэмжлэг үзүүлж байна. Түүнчлэн судалгааны хүрээлэнгүүд нь Хятадын тагнуулын байгууллагуудын үйл ажиллагааг халхавчлах, тэдгээрийн сонирхлыг татсан мэдээлэл цуглуулахад таатай халхавчийг бүрдүүлж байна.⁶⁴

Тав. Дүгнэлт

Тайванийг өртөө нэгтгэх бодлого нь нэг талаас Хятадын дотоод асуудал мэт ойлгогдож буй ч Тайванийн газар зүйн өвөрмөц байршил нь геополитикийн онолын үүднээс Хятадын бүс нутаг, олон улс дахь цэрэг стратегийн байр суурийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтойг харуулж байна. 2013 оноос хойш олон улс, бүс нутагт хэрэгжүүлж буй Хятадын гол стратеги нь “Бүс ба Зам” төсөл юм. Уг төслийн далайн зам нь чухамхүү Зах хөвөө тэнгис (Marginal Seas)-ийн шугамтай давхцадаг. Тайванийн өвөрмөц байршил нь зөвхөн цэрэг, стратегийн төдийгүй өндөр технологи, эдийн засгийн хувьд бүс нутагт хяналтаа тогтоох давуу талыг Хятад улсад олгоно.

Хятадын талаас Тайваньд тулгасан “Нэг Хятад” зарчим нь “Тайванийг өөртөө нэгтгэх” зорилтын суурь хэдий ч бодит байдал дээр энэхүү зорилт нь бүрэн хэрэгжиж чадаагүйн зэрэгцээ “Хоёр эрэг”-ийн харилцааг 3 удаа дайн бүхий байдалд хүргэжээ. Иймд “Нэг Хятад” зарчим нь “Нэг улс, Хоёр систем”, “92 зөвшилцөл”-өөр дүрээ хувиргах, уг зарчмыг хэрэгжүүлэх аргын хувьд хувьд хатуугаас “зөөлөн хүч”-д зайгаа тавьж өгөх хэлбэрт шилжиж ирэв. Энэ нь “Хүйтэн дайн”-ы дараах геополитикийн орчинд гарсан өөрчлөлт, Тайванийг хамгаалах АНУ-ын амлалт зэрэгтэй уялдсан бодлогын томоохон шилжилт юм. Гэхдээ

ямар ч тохиолдолд хятадын талын үндсэн байр суурь хэвээр бөгөөд зөөлөн хүч үр дүнд хүрэхгүй бол хатуу буюу зэвсгийн хүчээр Тайванийг эзлэх бодлогоос үл ухарна.

Хятадын “зөөлөн хүч”-ний бодлого нь онолын хувьд “Дайны 3 номлол”-д үндэслэж, мэдээлэл, сэтгэлзүйн талбарт Тайвань иргэдийн үзэл санаа, нийгмийн сэтгэлзүйд нөлөөлөх үр дүнтэй арга хэрэгсэл болж байна. Энэ нь АНУ-аас 1991, 2003 онд хэрэгжүүлсэн “Цөлийн шуурга” ажиллагаа, Иракт дайран орсон дайны бодит туршлагад тулгуурлаж буй бөгөөд “Хятадын ардын чөлөөлөх армийн улс төрийн ажлын дүрэм” зэрэг бодлогын баримт бичигт тусгалаа олжээ. Үүнийг Хятадын батлан хамгаалах стратегийн эргэлтийн цэг болсон хэмээн судлаачид үздэг.

Эх газраас Тайваньд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа нь улс төр, нийгэм, эдийн засаг, соёл, урлаг, хэвлэл мэдээлэл зэрэг өргөн талбарыг хамарч байна. Эдгээрийг бүхэлд нь хосолмол дайн (Hybrid Warfare)-ы тактик хэмээн тайлбарлаж бас болно. Ялангуяа Тайваньд чиглэсэн “31 зүйлт”, “26 зүйлт”, “22 зүйлт” хөтөлбөрүүд дээрх салбарыг бүхэлд нь хамарсан бөгөөд тодорхой зарим талбарт үр дүнгээ өгч байна. Гэвч “Тайванийг өөртөө нэгтгэх” улс төрийн зорилгыг

⁶⁴ 羅俊宏, [中共對臺「三戰」策略運用之研析] [“Хятадаас Тайваньд хэрэгжүүлж буй ‘3 дайн’-ы бодлого, үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ”], 復興崗學報 民 94, 85 期, 頁 60. [85-03 copy.pdf](#), 中共對臺「三戰」策略運用之研析 | Airiti Library 華藝線上圖書館

гол болгож буй учир бодит байдал дээр хэрэгжихэд олон хүндрэлтэй тулгарах болсон.

Тайваньд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд “Хоёр эрэг”-ийн үндэстний ижилсэл давуу байдлыг олгодог бол энэ нь тайваньчуудын хувьд хятадын талын үг, үйлдлийг таних, үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэхэд мөн эерэг нөлөө үзүүлдэг. Хоёр талыг бие биесээс нь заагладаг хамгийн том хүчин зүйл нь өнгөрсөн хугацааны ялгаатай тогтолцооны үр дүнд бүрэлдэн буй болсон нийтлэг үнэт зүйл, түүнийг хамгаалах иргэдийн жам ёсны сэтгэлгээ, хүсэл зоригийн илэрхийлэл юм. Энэ нь зайлшгүй харгалзан үзэх үндсэн хүчин зүйл болдог. Эх газраас нүүдэллэн ирсэн тайваньчууд цаг хугацааны эрхээр нийгмийн байр сууриа Тайвань арал дээр өсөж бойжсон залууст тавьж өгсөн нь өөр үзэл бодол, улс төрийн үзэл санаа, амьдралын хэв маяг бүхий цоо шинэ үе бүрэлдэхэд хүргэв.

Өөрөөр хэлбэл Эх газрыг “эх орон” гэж үздэг Тайванийн ахмад үеийг “тусгаар” Тайваньд төрж өссөн шинэ залуу үе түрэн гарч ирсэн. Энэ нь нийгмийн бүхэл бүтэн үе солигдох үйл явцын илрэл ажээ.

Эх газраас дүрвэн ирсэн олонх тайваньчууд Эх газрын соёл, уламжлалаа гэж амжаагүйн дээр хэзээ нэгэн цагт “Хоёр эрэг” нэгдэх нь гарцаагүй гэх үзэл бодлыг баримталж ирсэн бол Тайваньд төрсөн шинэ үеийн залуус “де факто улс” гэх ойлголтын дор өсч бойжин, улс төр, нийгмийн үйл хэрэгт оролцож эхэлсэн. Энэхүү нийгмийн хөрсөн дээр бий болсон Тайванийн эдийн засаг, батлан хамгаалах хүчин чадал, өндөр технологийн үсрэнгүй хөгжил, ардчилсан үнэт зүйл, өвөрмөц соёлын хүчин зүйл, АНУ тэргүүтэй барууны улс орнуудтай хөгжүүлж буй холбоо харилцаа нь Хятадын эрх баригчдын хувьд томоохон сорилт болж байна.

Ном зүй / References:

Эрх зүй, бодлогын баримт бичиг:

1. БНХАУ-ын Үндсэн хууль, Гуравдугаар бүлэг, 62-р зүйл, 62.14 дэх хэсэг, 1982 он. “Замбуулин” сэтгүүл, 2019, №1, 135-р тал.
2. Taiwan Relations Act, [H.R.2479 - 96th Congress \(1979-1980\): Taiwan Relations Act | Congress.gov | Library of Congress](#)
3. 反分裂國家法, 第九條, [反分裂國家法（主席令第三十四號）\(www.gov.cn\)](#)
4. 國家安全局, 〈中國假訊息心戰之因應對策〉(立法院外交及國防委員會會議), 第9屆, 第7期, 2019年5月2日。
5. 大会决议, 二七五八(二十六) . 恢复中华人民共和国在联合国的合法权利, [联合国大会第26届会议 | 大会决议 A/RES/2758\(XXVI\) \(un.org\)](#)
6. 聯合國大會第2758號決議, [聯合國大會第2758號決議 - 維基百科, 自由的百科全書 \(wikipedia.org\)](#)
7. 十四個堅持”基本方略 [【“十四個堅持”基本方略】--理論-人民網 \(people.com.cn\)](#)
8. 鄧小平, 鄧小平文選第3卷(台北: 地球出版社, 1994年), 頁94。
9. 习近平在中国共产党第十九次全国代表大会上的报告: [习近平在中国共产党第十九次全国代表大会上的报告【13】--新闻报道--人民网 \(people.com.cn\)](#)
10. 中共20大》習近平報告【完整版】: 提一中原則與九二共識, [中共20大》習近平報告【完整版】: 提一中原則與九二共識 | 遠見雜誌 \(gvm.com.tw\)](#)

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл:

11. Commander Michael Dahm, U.S. Navy (Retired), “China's Desert Storm Education”, March 2021. [China's Desert Storm Education | Proceedings - March 2021 Vol. 147/3/1,417 \(usni.org\)](#)
12. 劉遺倫, 「中國對台政策的歷史演變」, 黨史文苑, 2005年第6期, 頁15。
13. 周建勝, 「一國兩制是國家統一模式的政治倫理創新」, 成都大學學報(社科版)2010年第4期, 頁10。
14. 40年前今天 兩岸靠默契停火[金門炮擊 沒有白紙黑字簽署文件 說停就停], [40年前今天 兩岸靠默契停火 - 兩岸要聞 - 中國時報 \(chinatimes.com\)](#)
15. 空軍備役中校, 唐仁俊, [當前中共對台統戰策略之分析], 空軍軍官雙月刊第158期, 頁32。
16. 朱誠亮, 「中共對台政策演變論析」, 吉林省教育學院學報, 總231期, 2010年第3期, 頁134。
17. Ван Пуфэн, “Мэдээллийн дайны сорилтууд”, Хятадын цэргийн шинжлэх ухаан, №1, 1995. [THE CHALLENGE OF INFORMATION WARFARE Major General Wang Pufeng \(fas.org\)](#)
18. 劉文傑, [淺談中共當前對台三戰作為], 裝甲兵季刊, 第259期/民國110年3月, 頁21. https://www.mnd.gov.tw/NewUpload/202103/2-%E4%B8%AD%E5%85%B1%E7%95%B6%E5%89%8D%E5%B0%8D%E5%8F%B0%E4%B8%89%E6%88%B0%E4%BD%9C%E7%82%BA-%E5%8A%89%E6%96%87%E5%82%91_413844.pdf

19. 陳津萍, [習近平軍改前後「三戰」組織架構轉變研析], 陸軍學術雙月刊, 第五十四卷第 559 期 /2018 年 6 月, 頁 41. https://www.mnd.gov.tw/NewUpload/201805/p39-58_305151.pdf
20. 郭盛哲, 〈硬實力中的軟實力與銳實力：戰爭中的非軍事武力行動〉《復興崗學報》(台北市), 第 112 期, 國防大學政治作戰學院出版, 107 年 6 月, 頁 29-48。
21. 王聖元, [中共戰略支援部隊之研究], 陸軍砲兵季刊, 第 191 期/2020 年 12 月, 頁 70. https://www.mnd.gov.tw/NewUpload/202012/p69-85%E4%B8%AD%E5%85%B1%E6%88%B0%E7%95%A5%E6%94%AF%E6%8F%B4%E9%83%A8%E9%9A%A8%E4%B9%8B%E7%A0%94%E7%A9%B6_152700.pdf
22. 林穎佑, [中共戰略支援部隊的任務與規模], PROSPECT & EXPLORATION 第 15 卷 第 10 期 中華民國 106 年 10 月, 頁 109. https://www.mjib.gov.tw/FileUploads/eBooks/1a78a95eb4ab49f28342f0cb6b25ba93/Section_file/2898ca28058242a9849c0147c92fa511.pdf
23. 林正愷, [中共認知戰操作策略與我國因應作為], National Defense Journal Vol.36, No.1, MAR 2021, 頁 10. *001-022 網頁用 350062.pdf
24. 陳育正等, [由社群媒體的觀點論習近平主政後對臺 統戰策略對我國民眾的影響：以對臺 31 項措施為例], 中國大陸研究第 63 卷第 2 期, 頁 120. [陳育正 \(1\).pdf](#)
25. 羅俊宏, [中共對臺「三戰」策略運用之研析], 復興崗學報 民 94, 85 期, 頁 56. [85-03 copy.pdf](#)
26. 公方彬, 「輿論戰心理戰法律戰正式成為中國軍隊的作戰樣式—」, 中國青年報 (2004 年 4 月 11 日) . <http://news.beelink.com.cn/20040411/1560388.shtml>
27. 元樂義, 「和平崛起, 中共另覓對臺三戰」, 中國時報 (2004 年 4 月 19 日), <http://www.future-china.org.tw/fcn-tw/200404/2004041901.htm>
28. 台灣問題與新時代中國統一事業. [台灣問題與新時代中國統一事業 白皮書 中國政府網 \(www.gov.cn\) 机构设置 中共中央台湾工作办公室、国务院台湾事务办公室 \(gwyttb.gov.cn\)](#)
29. 洪銘德, 黃恩浩, [中共統戰工作之研究：以對台社會基層統戰為例], 復興崗學報 民 111 年 6 月, 120 期, 頁 56-57. [中共統戰工作之研究：以對台社會基層統戰為例 \(1\).pdf](#)

Холбогдох талуудын албан ёсны мэдэгдэл, үйл явдал, факт:

30. 关于印发《关于促进两岸经济文化交流合作的若干措施》的通知, [中共中央台湾工作办公室、国务院台湾事务办公室 \(gwyttb.gov.cn\)](#)
31. 关于进一步促进两岸经济文化交流合作的若干措施(全文), [关于进一步促进两岸经济文化交流合作的若干措施\(全文\) 新浪新闻 \(sina.com.cn\)](#)
32. 國台辦發言人介紹“農林 22 條措施”和其三大特點, [國台辦發言人介紹“農林 22 條措施”和其三大特點--台灣頻道--人民網 \(people.com.cn\)](#)
33. 台灣海峽歷次危機回顧：從一江山島戰役、金門炮戰到飛彈危機 看中美台三角關係演繹, [台灣海峽歷次危機回顧：從一江山島戰役、金門炮戰到飛彈危機 看中美台三角關係演繹 - BBC News 中文](#)
34. As it happened: China plans show of force after Pelosi's visit to Taiwan, [As it happened: Pelosi in Taiwan - China plans show of force after Pelosi's visit - BBC News](#)

35. 外交部发言人就瑙鲁政府宣布同台湾“断交”、愿同中国复交答记者问, [外交部发言人就瑙鲁政府宣布同台湾“断交”、愿同中国复交答记者问 \(china-embassy.gov.cn\)](http://china-embassy.gov.cn)
36. 陳鈺馥,〈習彈「通惠情」 陸委會: 統戰大於實質〉,《自由時報》
<https://news.ltn.com.tw/news/politics/paper/1458783>
37. 黃奕維, [由大陸「對臺 31 項措施」 觀察其對臺政策], PROSPECT & EXPLORATION 第 16 卷, 第 4 期, 中華民國 107 年 4 月, 頁 38.
https://www.mjib.gov.tw/FileUploads/eBooks/f344686292a247a1b9082d24096c7886/Section_file/70fabe81cdcd490688942707ebccb38b.pdf
38. 蔡英文: 我们没有需要宣布独立 因为已经是独立国家, [蔡英文: 我们没有需要宣布独立 因为已经是独立国家 - 政治 - 中时 \(chinatimes.com\)](http://chinatimes.com)
39. 520 就職演說 賴總統: 3 方向推動台灣發展, [520 就職演說 賴總統: 3 方向推動台灣發展 | 賴清德就任總統 | 要聞 | 聯合新聞網 \(udn.com\)](http://udn.com)
40. 看完賴清德 520 演說 陸國台辦回應了: 絕不容忍台獨行徑, [看完賴清德 520 演說 陸國台辦回應了: 絕不容忍台獨行徑 - 兩岸 - 中時 \(chinatimes.com\)](http://chinatimes.com)
41. 台湾人如何看待佩洛西访台行程, [台湾人如何看待佩洛西访台行程? - 纽约时报中文网 \(nytimes.com\)](http://nytimes.com)
42. 2024 年中华民国总统就职典礼, [2024 年中华民国总统就职典礼 - 维基百科, 自由的百科全书 \(wikipedia.org\)](http://wikipedia.org)
43. 中國再次舉行環台軍演, 警告賴清德, [中國再次舉行環台軍演, 警告賴清德 - 紐約時報中文網 \(nytimes.com\)](http://nytimes.com)
44. 日本 NHK 年度重磅纪录片「追踪中国泄露的文件」日本记者用半年時間, 走訪 7 個國家, 找寻 577 份泄密文件之真相。这些文件均涉及中国政军民三界, 集体进行跨境网络攻击及舆论操控的「认知战」行为。 [日本 NHK 年度重磅纪录片「追踪中国泄露的文件」日本记者用半年時間, 走訪 7 個國家, 找寻 577 份泄密文件之真相。这些文件均涉及中国政军民三界, 集体进行跨境网络攻击及舆论操控的「认知战」行为。 \(youtube.com\)](http://youtube.com)
45. 洪子傑、陳穎萱, [中國銳實力], <https://indsr.org.tw/uploads/indsr/files/202206/e3a60e10-a36a-4e11-82af-fc4e1ea58ede.pdf>, 頁 67.
46. 中国传砸钱渗透台湾网红艺人圈, [中国传砸钱渗透台湾网红艺人圈\(图\) 中共 | 文化 | 统战 | 时评 | 林乃绢 | 看中国网 \(secrechina.com\)](http://secrechina.com)

China's Policy and Activities Toward Taiwan

Bayarbaatar Jambaldorj

National Institute of Security Studies,

Ulaanbaatar, Mongolia

bayarbaatar.j@niss.gov.mn

Abstract: *Since 1949, The People's Republic of China has pursued the overarching objective of "reunifying" Taiwan, with its policies and practices consistently grounded in the principle of "One China." Over time, Beijing's approach has undergone a notable transformation, shifting from coercive strategies toward the framework of "One Country, Two Systems," a change that reflects broader geopolitical shifts in the post-Cold War era as well as the United States' commitment to Taiwan's security. More recently, Taiwan's Democratic Progressive Party (DPP) leadership has articulated positions such as "Taiwan is already a sovereign state" and "the mainland and Taiwan are mutually independent." These assertions have heightened Beijing's concerns, leading to statements that it "will not renounce the use of force if necessary" and to the staging of large-scale military exercises around the island, significantly intensifying regional tensions.*

This study examines the historical evolution and current trajectory of cross-Straits relations, examining the shifting policies of mainland China toward Taiwan. Particular attention is given to the theoretical underpinnings, mechanisms, and implementation of Beijing's strategy of "peaceful reunification," as well as to Taiwan's responses within the context of domestic political dynamics and external influences. Taiwan's countermeasures and strategies to resist pressure from the mainland will be the subject of a subsequent study.

Keywords: *Cross-Straits relations, Mainland China, Taiwan, One Country, Two Systems, 1992 Consensus, Three Warfares Doctrine*

The day of submission: 2025.09.18

Completion of review: 2025.10.30

Final decision for acceptance: 2025.11.06